

# ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын Үүд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн  
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2025/151/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорноговь аймаг 2025 он	Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор/Аудитор: Б.Алтанцэцэг Утас: 8000-7121 Цахим хаяг: Tolinetugen@gmail.com Аудитор Г.Шүрэнцэцэг Утас: 8905-6740 Цахим хаяг: Tolinetugen@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	12
3.1 Төлбөрийн акт .....	12
3.2 Албан шаардлага .....	12
3.3 Зөвлөмж .....	12
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	13

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гуламж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025.02.25 № 1-6/2025

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ЗАМЫН ҮҮД СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Т.БАТТУЯА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын Үүд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

МОНГОЛ  
442502077

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудлын хэсэг**

2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 93.5% хувийн биелэлттэй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ





## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>315,905,131.40</b>	<b>398,101,488.82</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	171,140,304.64	224,159,798.16
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	171,140,304.64	224,159,798.16
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	171,140,304.64	224,159,798.16
31211	Төрийн сангийн харилцах	171,140,304.64	224,159,798.16
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	196,500.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	196,500.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	144,568,326.76	173,941,690.66
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	12,861,200.00	-
35110	Тусгай зориулалттай материал	12,861,200.00	-
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	131,707,126.76	173,941,690.66
35410	Бичиг хэргийн материал	23,566,007.61	26,605,507.61
35420	Аж ахуйн материал	107,641,119.15	124,332,219.15
35440	Түлш, шатах тослох материал	500,000.00	240,000.00
35460	Хүнсний материал	-	11,733,400.00
35470	Бусад хангамжийн материал	-	11,030,563.90
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,397,231,644.95</b>	<b>4,461,820,595.59</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,397,231,644.95	4,461,820,595.59
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,127,087,727.99	4,191,820,595.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,019,233,970.00	4,164,603,970.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(327,190,072.86)	(400,531,589.06)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	374,976,148.56	468,497,438.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(112,846,087.72)	(202,215,002.53)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	254,012,147.41	275,020,887.41
39208	Хуримтлагдсан элэгдэл	(132,447,601.51)	(165,004,332.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,600,000.00	18,600,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(18,101,666.99)	(18,361,667.03)
39217	Ном	50,850,891.10	51,210,891.10
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	270,143,916.96	270,000,000.00
39301	Програм хангамж	1,727,000.00	1,727,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,583,083.04)	(1,727,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	270,000,000.00	270,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,713,136,776.35</b>	<b>4,859,922,084.41</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>300,025.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	300,025.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	300,025.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	300,025.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,713,136,776.35</b>	<b>4,859,622,059.41</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,713,136,776.35	4,859,622,059.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	270,000,000.00	270,000,000.00
51101	Өмч: - төрийн		270,000,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	3,374,432,723.39	3,520,918,006.45
51210	Өмнөх үеийн үр дүн	3,374,432,723.39	3,374,432,723.39
51220	Тайлант үеийн үр дүн	-	146,485,283.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,068,704,052.96	1,068,704,052.96
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,713,136,776.35</b>	<b>4,859,922,084.41</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,813,277,709.38</b>	<b>3,911,454,359.04</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>134,656,264.82</b>	<b>242,956,191.90</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	134,656,264.82	242,956,191.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	134,656,264.82	242,956,191.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,353,400.00	4,858,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		20,036,398.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	118,617,311.10	195,223,030.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	9,685,553.72	22,838,563.90

<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,678,621,444.56</b>	<b>3,668,498,167.14</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,322,927,200.00	3,211,565,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,322,927,200.00	3,211,565,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	46,722,825.00	91,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,350,000.00	91,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,372,825.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	308,971,419.56	365,432,667.14
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	308,971,419.56	365,432,667.14
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	-	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,641,513,158.44</b>	<b>3,764,969,075.98</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,641,513,158.44</b>	<b>3,764,969,075.98</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,463,006,658.44	3,516,698,575.98
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,649,480,289.62	2,454,805,930.18
210101	Үндсэн цалин	1,106,981,025.18	1,540,925,872.18
210102	Нэмэгдэл	483,517,459.95	846,441,852.00
210104	Урамшуулал	58,981,804.49	67,438,206.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	209,764,013.00	313,789,900.00
210201	Тэтгэврийн даатгал	142,432,609.00	213,377,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	16,838,613.00	25,103,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,451,561.00	12,551,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,378,600.00	12,551,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	33,662,630.00	50,206,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	300,971,419.56	357,432,667.14
210301	Гэрэл, цахилгаан	17,525,399.56	20,931,566.31
210302	Түлш, халаалт	266,246,020.00	319,101,100.83
210303	Цэвэр, бохир ус	17,200,000.00	17,400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	26,236,500.00
210401	Бичиг хэрэг	-	9,941,900.00
210402	Тээвэр, шатахуун	-	6,460,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	9,834,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	240,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	240,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,044,500.00	13,041,000.00
210604	Урсгал засвар	7,044,500.00	13,041,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	15,125,300.00	34,648,711.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,130,300.00	5,302,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,995,000.00	29,346,411.30
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	280,621,136.26	316,503,167.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,526,183.54	83,742,888.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,921,200.00	37,089,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	172,173,752.72	195,671,079.36
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	178,506,500.00	248,270,500.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	178,506,500.00	248,270,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	131,488,500.00	151,570,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	47,018,000.00	96,700,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>171,764,550.94</b>	<b>146,485,283.06</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>171,764,550.94</b>	<b>146,485,283.06</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,684,974,844.56</b>	<b>3,703,392,765.14</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,353,400.00</b>	<b>34,894,598.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	6,353,400.00	34,894,598.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	6,353,400.00	24,894,598.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,858,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,353,400.00	20,036,398.00
120009	Бусад орлого	-	10,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,678,621,444.56</b>	<b>3,668,498,167.14</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,322,927,200.00	3,211,565,500.00

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,322,927,200.00	3,211,565,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>46,722,825.00</b>	<b>91,500,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,350,000.00	91,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,372,825.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>308,971,419.56</b>	<b>365,432,667.14</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	308,971,419.56	365,432,667.14
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,467,797,136.72</b>	<b>3,585,336,271.62</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,467,797,136.72</b>	<b>3,585,336,271.62</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,289,290,636.72</b>	<b>3,332,631,371.62</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,649,480,289.62</b>	<b>2,464,309,405.18</b>
210101	Үндсэн цалин	1,106,981,025.18	1,550,429,347.18
210102	Нэмэгдэл	483,517,459.95	846,441,852.00
210104	Урамшуулал	58,981,804.49	67,438,206.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>209,764,013.00</b>	<b>313,789,900.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	142,432,609.00	213,377,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	16,838,613.00	25,103,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,451,561.00	12,551,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,378,600.00	12,551,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	33,662,630.00	50,206,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>300,971,419.56</b>	<b>357,432,667.14</b>
210301	Гэрэл, цахилгаан	17,525,399.56	20,931,566.31
210302	Түлш, халаалт	266,246,020.00	319,101,100.83
210303	Цэвэр, бохир ус	17,200,000.00	17,400,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,000,000.00</b>	<b>8,000,000.00</b>
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,125,300.00</b>	<b>64,471,720.30</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,130,300.00	5,302,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,995,000.00	59,169,420.30
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>105,949,614.54</b>	<b>124,627,679.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,120,314.54	96,376,979.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,829,300.00	28,250,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>178,506,500.00</b>	<b>252,704,900.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>178,506,500.00</b>	<b>252,704,900.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	131,488,500.00	156,004,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	47,018,000.00	96,700,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>217,177,707.84</b>	<b>118,056,493.52</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>75,427,000.00</b>	<b>65,037,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>75,427,000.00</b>	<b>65,037,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>75,427,000.00</b>	<b>65,037,000.00</b>
222001	Тоног төхөөрөмж	62,377,000.00	62,847,000.00
223001	Бусад хөрөнгө	13,050,000.00	2,190,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(75,427,000.00)</b>	<b>(65,037,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>141,750,707.84</b>	<b>53,019,493.52</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>171,140,304.64</b>	<b>171,140,304.64</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>171,140,304.64</b>	<b>224,159,798.16</b>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНИЙ НИЙТ ДҮН
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	270,000,000.00	1,068,704,052.96	3,202,668,172.45	4,541,372,225.41
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>270,000,000.00</b>	<b>1,068,704,052.96</b>	<b>3,202,668,172.45</b>	4,541,372,225.41
Тайлант үеийн үр дүн	-	-	171,764,550.94	171,764,550.94
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>270,000,000.00</b>	<b>1,068,704,052.96</b>	<b>3,374,432,723.39</b>	4,713,136,776.35
<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>270,000,000.00</b>	<b>1,068,704,052.96</b>	<b>3,374,432,723.39</b>	4,713,136,776.35
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>270,000,000.00</b>	<b>1,068,704,052.96</b>	<b>3,374,432,723.39</b>	4,713,136,776.35
Тайлант үеийн үр дүн	-	-	146,485,283.06	146,485,283.06
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>270,000,000.00</b>	<b>1,068,704,052.96</b>	<b>3,520,918,006.45</b>	4,859,622,059.41

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	3,899,216,700.00	3,645,073,271.62
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,899,216,700.00	3,645,073,271.62
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,612,499,600.00	3,389,868,371.62
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,607,476,600.00	2,464,309,405.18
210101	Үндсэн цалин	1,647,491,600.00	1,550,429,347.18
210102	Нэмэгдэл	889,355,500.00	846,441,852.00
210104	Урамшуулал	70,629,500.00	67,438,206.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	325,934,700.00	313,789,900.00
210201	Тэтгэврийн даатгал	221,635,600.00	213,377,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	26,074,800.00	25,103,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,037,400.00	12,551,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	13,037,400.00	12,551,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	52,149,500.00	50,206,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	387,943,100.00	357,432,667.14
210301	Гэрэл, цахилгаан	29,760,000.00	20,931,566.31
210302	Түлш, халаалт	340,783,100.00	319,101,100.83
210303	Цэвэр, бохир ус	17,400,000.00	17,400,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,000,000.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	80,310,300.00	68,679,120.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,807,200.00	5,302,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	74,503,100.00	63,376,820.30
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	202,834,900.00	177,657,279.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	174,584,200.00	149,406,579.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,250,700.00	28,250,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	286,717,100.00	255,204,900.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	286,717,100.00	255,204,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	176,217,100.00	163,804,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	110,500,000.00	91,400,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	3,899,216,700.00	3,693,392,765.14
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	3,211,565,500.00	3,303,065,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,211,565,500.00	3,211,565,500.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	395,943,100.00	365,432,667.14
132001	Орон нутгийн төсвөөс	395,943,100.00	365,432,667.14
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	291,708,100.00	24,894,598.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,584,100.00	4,858,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	131,525,300.00	20,036,398.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	154,598,700.00	

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 19,820.0 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрсэн байна. Үүнээс 19,820.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгч ажилласан.

#### **3.1 Төлбөрийн акт**

2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

#### **3.2 Албан шаардлага**

2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага тогтоогдоогүй болно.

#### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Төсвийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Тус аймгийн Замын Үүд сумын ЗД-ын 2024.07.23-ны өдрийн Б/20, 2024.08.14-ний өдрийн Б/21, 2024.09.20-ны өдрийн Б/28, 2024.10.25-ны өдрийн Б/31 дугаар захирамжийн дагуу байгууллагын ажилтан, албан ажилчдад сар бүр олгох 100.0 мянган төгрөг, нийт 91,500.0 мянган төгрөгийг олгохдоо ажил олгогчоос төлөх 9.353.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, даатгуулагчаас төлөх 7,198.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутган аваагүй, нийт 19,520.0 мянган төгрөгийг НДШ төлөөгүй зөрчил байна.

##### Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын тухай хуулийн 21.1. “Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө” заалтыг хэрэгжүүлж ажиллах.

##### Илрүүлэлт:

2024 оны санхүүгийн байдлын тайланд 300.0 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл тайлагнасан байна.

##### Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг хэрэгжүүлж өр авлага үүсгэхгүй, төсвийг зохистой удирдаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

